

---

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН  
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

---

**“ЁЛ РЕСУРС” ХХК**

## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....   | 3  |
| 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН<br>ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....           | 6  |
| 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ<br>ТОДОРХОЙЛОЛТ.....   | 7  |
| 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>ГОЛ ЗОРИЛТ .....  | 13 |
| 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 14 |
| 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....   | 16 |
| 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br>ТӨЛӨВЛӨГӨӨ.....  | 17 |
| 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВРИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....  | 17 |
| 9. ОСОЛ ЭРСДЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....   | 18 |
| 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....   | 20 |
| 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....   | 22 |
| 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ<br>ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ       | 24 |
| 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ . | 26 |

### Зургийн жагсаалт

|   |   |
|---|---|
| Зураг 1. Нүүрс ачиж буулгах талбай .....            | 3 |
| Зураг 2. Технологийн процесс .....                  | 3 |
| Зураг 3. Оффис, ажилчдын байр .....                 | 4 |
| Зураг 4. Оффис, ажилчдын байрны дотоод байдал ..... | 4 |
| Зураг 5. Техник, тоног төхөөрөмж .....              | 5 |
| Зураг 6. Судалгааны талбайн байршил .....           | 6 |

### Хүснэгтийн жагсаалт

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон үйл ажиллагаатай<br>холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт ..... | 8  |
| Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх<br>хугацаа, эрчим .....                                 | 10 |
| Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал .....   | 27 |

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ёл ресурс” ХХК нь уурхайнуудаас нүүрс худалдан авч, нөөцлөн, шилжүүлэн ачиж экспортлох зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Цагаан хаданд нийт 10 га талбайд 2012 оноос Гаалийн хяналтын талбай байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.

### **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB tower, place офисс, 12 давхар  
1206 тоот Ёл групп

Утас: 99111811, 86888585, 89284040

“Гаалийн хяналтын талбай” нь нийт 10 га талбайтай.


- Нүүрс ачих буулгах талбай
- Ажилчдын суурин, оффисын байр

### **Нүүрс ачиж буулгах талбай**

Эзэмшил талбай 300000 тн ачаа хүлээн авах хүчин чадалтай бөгөөд хоногт 100-150 автомашин хүлээж авах боломжтой. Өдөрт 500 орчим, сард 65000 тн нүүрс буулгаж, мөн тэр хэмжээний нүүрсийг ачиж, Гашуун сухайтын боомтоор нэвтрүүлнэ.



Зураг 1. Нүүрс ачиж буулгах талбай



Зураг 2. Технологийн процесс

## Барилга байгууламж

Гаалийн хяналтын талбайд стандартын дагуу шинэ шатанд гаргах ажлын хүрээнд ажилтан, хамтран ажиллагчдын амьдрах орчин ая тухтай байдлыг өндөр түвшинд тавьж, орчин үеийн сантехник цэвэр бохирын асуудлыг шийдсэн боловсон 00, халуун ус, зоогийн газар, оффис, өрөөнүүд гэх мэт байрыг барьж тохижуулсан.

- Гал тогоо, хоолны зал, амрах өрөө бүхий ажилчдын байр - 108.9 м<sup>2</sup> (33м х 3.3м)
- Гаалийн хяналтын байр болон пүүний байшин - 27 м<sup>2</sup> (3м х 9м)
- Засварын газар 20 м<sup>2</sup> (4м х 5м)
- Барааны агуулах 20 м<sup>2</sup> (4м х 5м)
- Харуулын байр зэрэг барилга байгууламжууд



*Зураг 3. Оффис, ажилчдын байр*



*Зураг 4. Оффис, ажилчдын байрны дотоод байдал*

## ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- Ковш - 3ш
- Өдөр тутмын үйлчилгээний машин - 2ш
- Цахилгааны мотор - 1ш
- Сэрээт ачигч по-1ш
- Хяналтын жин /200 тн-ын даацтай/-2ш




*Зураг 5. Техник, тоног төхөөрөмж*

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

“Гаалийн хяналтын талбай” нь Өмнөговь аймгийн Ханбогд сум нутаг дэвсгэр Цагаан хад хэмээх газарт сумын төвөөс зүүн урагш 70км, Гашуун Сухайтын хилийн боомтоос 23 км-т байрлана.

“Ёл ресурс” ХХК нь тус сумын засаг даргын 2018 оны 02 сарын 05-ний өдрийн А/34 дугаар захирамжийг үндэслэн 4601008730 тоот нэгж талбар бүхий 10 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрх авсан байна.



Зураг 6. Судалгааны талбайн байршил

### Усан хангамж

Хэрэглээний усаа талбайгаас 10км зайд байрлах өрөмдмөл гүний худгаас ус түгээгч хувь хүнээр дамжуулан авдаг ба 2тн-ны тээврийн хэрэгслээр усыг зөөвөрлөдөг.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг зөв оновчтой тогтоох нь байгальд ихээхэн хэмжээний хохирол учруулан, эвдрэл доройтолд орохоос сэргийлэн улмаар хүрээлэн буй орчныг хамгаалах чухал арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжих талбай нь Монгол улсын хилийн бүсэд нутагт байрлах тул нүүрс ачиж буулгах бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхгүй байх шаардлагатай болно.

Монгол орны нөхцөлд гаалийн хяналтын бүсийн хувьд онц аюултай хүчтэй салхи, үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай бөгөөд энэ тухай энэ тайланд тодорхой дурдсан болно.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Төслийн үйл ажиллагаа дараалал, барилга байгууламжийн өнөөгийн шийдлийг 2 дугаар бүлэгт авч үзсэн. Талбайд нүүрс буулгах, ачихтай холбоотой үүсч буй тоосжилтыг бууруулах, усан хангамжийн шийдэл, төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчин болон нийгмийн хамгааллын арга хэмжээний асуудлыг тодорхой болгосон төлөвлөлтүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байгаа нь тогтоогдсон тул зардлыг нарийвчлан тооцож, энэ ажлыг чухам хэн хариуцаж, хэзээ гүйцэтгэх зэргийг тодорхой болгох шаардлага зайлшгүй гарч байгаа.

Барилга байгууламж барих болон үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал

Гаалийн хяналтын талбай нь жилийн турш зогсолтгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд цаашдаа төслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилго тавьж байна. Нүүрс тээвэрлэлт байнга хийгдэнэ. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад элэгдэж эвдрэлд орсон талбайн тохижилт, техникийн нөлөөллөөс хамгаалсан хатуу хучилт, салхины хаалт зэргийг хийж тоосжилт бууруулах нөхцөлийг хангах нь зүйтэй юм.

Түлш шатахуун, шатах тослох материалыг ашиглах явцад осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлаж байх шаардлагатай болно. Мөн хог хаягдлын ангилсан стандартын шаардлага хангасан цэг байгуулах, бохир усыг дахин ашиглах, ариутгах, цэвэрлэх зэрэг ажлыг судалж нэвтрүүлэн үлгэр жишээ байх хэрэгтэй. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөж ажиллах шаардлагатай.



## Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийн үйл ажиллагааны үед байгаль хамгаалах ажлыг бодитойгоор төлөвлөх, өөрөөр хэлбэл санхүүгийн болон хариуцлагын тогтолцооны түвшинд гол анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед уг талбайн байршил, төслийн техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

### Хүснэгт 1. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

|  | Байгаль орчны асуудлууд   | Нөлөөллийн үр дагавар |      |      |    |
|--|---|-----------------------|------|------|----|
|  |   | Нөлөөлөхгүй           | Бага | Дунд | Их |
| <b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>                       |   |                       |      |      |    |
| 1.   | Голын гольдролыг эвдэж, өөрчлөх   | х                     |      |      |    |
| 2.   | Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал   | х                     |      |      |    |
| 3.   | Үерийн аюулд өртөх  |                       | х    |      |    |
| 4.   | Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх  | х                     |      |      |    |
| 5  | Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх  | х                     |      |      |    |
| 6  | Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх   | х                     |      |      |    |
| <b>2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал</b>            |   |                       |      |      |    |
| 7  | Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, түүхий эдийг ачиж буулгах, хадгалах болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой |                       | х    |      |    |
| 8  | Осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн  |                       |      | х    |    |
| 9  | Үйл ажиллагааны үеийн үерийн хамгаалалтын асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой  |                       |      | х    |    |
| 10   | Төсөл хэрэгжүүлэх үед хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой   | х                     |      |      |    |
| 11   | Ус хэрэглэх, усны чанарыг хамгаалах, хянах асуудал  |                       |      | х    |    |
| 12   | Ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон дуу чимээ гарах   |                       |      | х    |    |
| 13   | Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх   |                       |      |      | х  |
| 14   | Төслийн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх   |                       | х    |      |    |
| <b>3. Барилга байгууламж барих, засахтай холбогдож гарах байгаль орчны асуудал</b> |   |                       |      |      |    |

|   |  |            |            |            |            |
|---|--|------------|------------|------------|------------|
| 15  | Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал   | x          |            |            |            |
| 16  | Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл  |            |            | x          |            |
| 17  | Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл   |            |            | x          |            |
| <b>4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал</b>                           |  |            |            |            |            |
| 18  | Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх   |            |            |            | x          |
| 19  | Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх  |            |            | x          |            |
| 20  | Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)   |            | x          |            |            |
| 21  | Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх  | x          |            |            |            |
| 22  | Газар ашиглалтад хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булаах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтад гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх |            | x          |            |            |
| 23  | Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)   |            | x          |            |            |
| 24  | Төслийн талбайг өөр зориулалтаар ашиглах боломжийг авч үзсэн эсэх  | x          |            |            |            |
| 25  | Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал  |            |            |            | x          |
| <b>5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)</b> |  |            |            |            |            |
| 26  | Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах   | x          |            |            |            |
| 27  | Төслийн техник технологийн шийдлийг техник, эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал   |            | x          |            |            |
| <b>Нөлөөллийн үнэлгээний тоон утгын хувь</b>                                      |  | <b>37%</b> | <b>26%</b> | <b>26%</b> | <b>11%</b> |

Төслийн байршил, техник технологийн шийдэл болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх болзошгүй нөлөөллийн дүнгээс үзэхэд 37.0 хувь нь нөлөөлөлгүй, 26 хувь нь бага, 26 хувь нь дунд, 11 хувь нь их нөлөөлөл үзүүлэхээр байна.

Гаалийн хяналтын талбайд нүүрс ачиж буулгах явцад үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим, мөн уг нөлөөллөөс байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэхийг тодруулах) болзошгүй нөлөөллийн үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

| Нөлөөллийн төрөл  | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Сулавтар нөлөөлөх | Дунд зэрэг нөлөөлөх | Хүчтэй нөлөөлөх |
|---|------|----------|---------------------|------------------|-----|----------------|--------------------|-------------------|---------------------|-----------------|
| <b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Гадаргын усны урсцын өөрчлөлт   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Гадаргын усны чанарын өөрчлөлт  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт   |      | x        |                     |                  | x   |                | x                  |                   | x                   |                 |
| Хөрсний элэгдэл, эвдрэл   |      | x        |                     |                  | x   |                | x                  |                   | x                   |                 |
| Геологийн тогтцын өөрчлөлт  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт   |      | x        | x                   | x                |     |                |                    | x                 |                     |                 |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт  |      | x        | x                   | x                |     |                |                    | x                 |                     |                 |
| <b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Газрын гадаргын нөөц баялаг   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Бэлчээр, тэжээлийн байдал   |      |          | x                   |                  |     |                |                    | x                 |                     |                 |
| Эрдэс түүхий эдийн нөөц   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Эрчим хүчний нөөц   |      | x        |                     |                  | x   | x              |                    |                   | x                   |                 |
| <b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Ундны усны чанар, хэмжээ  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Урсгал усны хэрэгцээ  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Агаарын бохирдол  | x    |          |                     | x                |     |                |                    | x                 |                     |                 |
| Хөрсний бохирдол  |      | x        |                     |                  | x   |                | x                  | x                 |                     |                 |
| Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Дуу чимээ, шуугианы нөлөөлөл  | x    |          |                     | x                |     |                |                    |                   | x                   |                 |
| <b>4. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх  | +    |          |                     |                  | +   |                | +                  |                   | +                   |                 |
| Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх  |      | +        |                     | +                |     | +              |                    |                   | +                   |                 |
| Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх   |      | +        |                     |                  | +   |                | +                  |                   | +                   |                 |
| Хүн амын тоо өөрчлөгдөх   | +    |          |                     | +                |     | +              |                    | +                 |                     |                 |
| <b>5. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b> |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх  | x    |          |                     |                  | x   |                | x                  | x                 |                     |                 |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх  | x    |          |                     |                  | x   |                | x                  | x                 |                     |                 |
| Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх  |      | x        | x                   |                  | x   |                | x                  | x                 |                     |                 |
| Түүх соёлын дурсгал зүйлд нөлөөлөх  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Археологи, палентологийн олдворт нөлөөлөх   |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| <b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |
| Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх  | +    |          |                     |                  | +   |                | +                  |                   | +                   |                 |
| Орон нутгийн орлого нэмэгдэх  | +    |          |                     |                  | +   |                | +                  |                   | +                   |                 |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох  | +    |          |                     |                  | +   |                | +                  | +                 |                     |                 |
| Ажлын байр нэмэгдэх   | +    |          |                     | +                |     |                | +                  |                   | +                   |                 |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх  |      | +        |                     |                  | +   |                | +                  |                   | +                   |                 |
| <b>7. Бусад нөлөөлөл</b>  |      |          |                     |                  |     |                |                    |                   |                     |                 |

|  |           |           |          |          |           |          |           |           |           |  |
|--|-----------|-----------|----------|----------|-----------|----------|-----------|-----------|-----------|--|
| Шороон зам харилцаа машин<br>механизмын хөдөлгөөн шилжилтээс<br>болж хөрс эвдрэх           | x         |           |          |          | x         |          | x         | x         |           |  |
| Ахуйн бохир ус, нефтийн<br>бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба<br>грунтын усыг бохирдуулах | x         |           |          |          | x         |          | x         | x         |           |  |
| Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал<br>муугаас эвгүй үнэр гарах,<br>шавж үржих           | x         |           |          | x        |           | x        | x         | x         |           |  |
| <b>ДҮН</b>   | <b>13</b> | <b>10</b> | <b>4</b> | <b>8</b> | <b>15</b> | <b>4</b> | <b>16</b> | <b>13</b> | <b>11</b> |  |

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Дээрх хүснэгтээс үзэхэд гаалийн хяналтын талбай цаашид үйл ажиллагаа явуулахад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл 11, бусад сөрөг нөлөөлөл 3 буюу бүгд сөрөг нөлөөлөл 14, нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл 10 болж нийт 24 нөлөөлөл болж байна. Үүнээс:

**Шүүд нөлөөлөл.** Байгаль орчин, экологид үзүүлэх болзошгүй нөлөөллийн 4 нь шууд нөлөөлөлд хамаарахаар байна. Эдгээрт нүүрсийг ачиж буулгахаас үүсэх тоос, машин техникийн дуу чимээ, үүнтэй уялдан хэсэг газрын ландшафт өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл байна. Түүнчлэн зам тээврийн харилцаанаас үүсэх хэсэг газрын хөрс эвдрэх, хөрсний элэгдэл үүсэх, ургамлын бүтэц өөрчлөгдөх, ахуйн бохир ус, хог хаягдлын цэгийн ариутгалыг муу хийснээс орчин бохирдох нөхцөлийг бүрдүүлж байна.

**Шүүд бус нөлөөлөл.** Барилга байгууламж барихад өртсөн газар болон нүүрс ачиж

буулгах хэсэгт хөрс эвдрэх, бохирдох, уур амьсгалын бичил өөрчлөлт гарах, дуу чимээнээс зэрлэг ан амьтад дайжих, санамсар болгоомжгүйгээс хээрийн болон тухайн газарт түймэр гарах зэрэг нөлөөлөл байж болно. Түүнчлэн тусгай хамгаалалтай газар нүүрсний ачилтын үед гарсан тоосонцор салхиар тээгдэн хөрсийг бүрхэх замаар тухайн хэсгийн хөрс ургамалд нөлөөлж болзошгүй. Эндээс 4 нөлөөлөл нь эерэг, 6 нөлөөлөл сөрөг нийт 10 нөлөөллийг үзүүлж болно.

**Богино хугацааны нөлөөлөл.** Цаг агаарын хуурай үед машин механизмын үйл ажиллагааны дүнд их хэмжээний тоос агаарт гарах, салхитай үед нүүрс ачилтаас тоос хийсэх, хүнд механизмын хөдөлгүүрийн дотоод шаталт, дизель станцыг ажиллуулахад ялгарах нефть бүтээгдэхүүний хорт хий, утаа зэргээс агаар богино хугацаанд бохирдоно. Түүнчлэн хүнд механизмын дуу чимээ болон ачилтын үе дэх тоног төхөөрөмжийн дуу чимээ агаарт тархана. Дуу чимээ тооноос амьтад зайлна. Агаарт тархсан нүүрсний тоос агаарыг богино хугацаанд түр бохирдуулж, ажиллагсдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, ойр орчмын хөрс, ургамал, бэлчээрийн талбай тоосонд дарагдаж өөрийн унаган төрхөө алдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржихэд хүрч болох нь

мөн богино хугацааны нөлөөлөлд хамаарна. Иймд салхи ихтэй үед утаа ба тоос шорооны бохирдлыг багасгах зорилгоор дизель хөдөлгүүрийн утааны янданд шүүлтүүр тавих, ухагдсан хөрс шороо, машин механизмд талхлагдсан орчны газрыг ялангуяа авто замыг шаардлагатай үед усалж, чийглэж байх зэрэг нэмэлт арга хэмжээг авч байх нь зүйтэй. Хог хаягдлын цэгийг графикийн дагуу ариутгаж байх хэрэгтэй. Нийт богино хугацааны нөлөөлөл 8 байгаагаас эерэг-4, сөрөг-4 байна.

**Урт хугацааны нөлөөлөл.** Хүснэгтээс үзэхэд нүүрс ачиж буулгах үед байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн ихэнх нь буюу 15 нь удаан хугацаагаар буцалтгүй нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, хөрсний бохирдол зэрэг сөрөг нөлөөллөөс гадна дэд бүтцийн хөгжил, цахилгаан эрчим хүчээр хангагдах, хүн амын болон нутгийн орлого нэмэгдэх зэрэгт буцалтгүй эерэгээр нөлөөлөхөөр (7 нөлөөлөл) харагдаж байна.

**Буцаж нөлөөлөх нөлөөлөл.** Энэхүү нөлөөлөлд ахуйн хог хаягдлын ариутгалыг хийгээгүйгээс хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөлөх, мөн амьтанд нөлөөлөх магадлалтай байна гэж үздэг. Тухайн үйл ажиллагааны хувьд цацраг идэвхт бодис ашиглахгүй. Гэвч экспортлож буй нүүрсний цацраг идэвхт байдлыг шинжлүүлэн тодорхойлоход цаашид анхаарах хэрэгтэй. Хорт хийн хувьд машин техникийн утаа агаарын хольцноос өөр богино хугацаанд үзүүлэх нөлөөлөл байхгүй болно. Нүүрсний агуулахад удаан хугацаагаар их хэмжээгээр нүүрс хадгалагдахад хүрвэл нүүрсний өөрөө шаталтаас сэргийлэх арга хэмжээг авсан байвал зохионо. Энэ талаар байгаль орчны жилийн төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Энэ тээвэрлэлтийн систем ажиллах хугацаанд хүн амын тоо нэмэгдэж, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө. Нийт нөлөөллийн тоо 4-өөс эерэг-3, сөрөг-1 хүчин зүйл байна.

**Нөлөөллийн эрч, хүч.** Болзошгүй нөлөөллийн ихэнх нь бага-13, үүнээс эерэг-2, сөрөг-11, дунд -11 үүнээс эерэг-8, сөрөг-3, хүчтэй -0 зэрэгт хамаарч нийт 24 нөлөөллийн 14 нь сөрөг буюу 58.30%, 10 нь эерэг буюу 41.70%-ийг эзэлж байна. Иймээс нөхөн сэргээх асуудалд тоосноос хамгаалах ажил ялангуяа салхины хүчийг сааруулах зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна. Ялангуяа энэ нь нүүрс агуулах талбайн ачих буулгах талбайд хамаарагдаж байна.

Иймээс байгаль байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн ажлын онцлогтой холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь гаалийн хяналтын талбай байршиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Тиймээс төслийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах, нөхцөлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

